

2019 ОНД ЭКСПОРТЛОХ СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Шалгаруулалтын дугаар: СХЭИЗОСШ - 20190904

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалт, “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам” Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсантай холбогдуулан 2019 онд экспортлох стратегийн хүнс **/АДУУНЫ МАХ/**-ний нэр төрөл, тоо, хэмжээнд багтаан зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Оролцогч нь дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, битүүмжлэн, **2019** оны **9** дүгээр сарын **13**-ны өдрийн 16 цаг 00 минутаас өмнө Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны 502 тоот өрөөнд бүртгүүлж, хүлээлгэн өгнө. Үүнд:

1. Экспортлох хүнсний нэр төрөл, тоо хэмжээг заасан албан бичиг;
2. Хуулийн этгээдийн нэр, байршил, хаяг, утас, цахим хаяг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, эрхэлж байгаа хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр;
3. Татварын өргүй болохыг нотолсон харьяалах татварын албаны тодорхойлолт (2019 оны 9 дүгээр сарын 10-ны байдлаар);
4. Аудитаар баталгаажсан сүүлийн жилийн санхүүгийн тайлангийн хуулбар;
5. Хуулийн этгээдийг төлөөлөн сонгон шалгаруулалтад оролцох этгээдийн итгэмжлэл олгосон эрх бүхий албан тушаалтны шийдвэр;
6. Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан үйлдвэрийн байртай болохыг нотолсон мэргэжлийн хяналтын байгууллагын тодорхойлолт;
7. Импортлогч улсын үйлдвэр, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан худалдааны гэрээ;
8. Импортлогч орны мал эмнэлэг, хорио цээрийн албаны эрх бүхий байгууллагаас итгэмжлэгдсэн байх;
9. Хүн амын хүнсний хангамжийг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд яамтай бодлогын гэрээ байгуулахад татгалзах зүйлгүй талаар мэдэгдсэн албан бичиг;
10. 2019 онд экспортлох мах бэлтгэлийн төлөвлөгөө, мал эмнэлгийн гэрчилгээ;

Сонгон шалгаруулалтад оролцогчийн материалыг хүлээн авах эцсийн хугацаа: **2019** оны **9** дүгээр сарын **13**-ны өдрийн 16 цаг 00 минут /Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахгүй/

Ирүүлсэн материалыг нээх хугацаа: **2019** оны **9** дүгээр сарын **13**-ны өдрийн 17 цаг 00 минут

ХАЯГ:

**Монгол Улс, Улаанбаатар-13381, Энхтайваны өргөн чөлөө 16а,
Засгийн газрын 9 дүгээр байр, Б корпус, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
яамны 5 давхарт, 502 тоот өрөө, Утас: 261962**